

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор:
Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 83
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.СҮХБОЛД
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>609,278,147.40</u>	<u>736,817,936.40</u>
33	АВЛАГА	1,314,599.00	108,044,388.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	414,599.00	00.00
335	Бусад авлага	900,000.00	108,044,388.00
3351	Байгууллагаас авах авлага	900,000.00	41,309,388.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	66,735,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	607,963,548.40	628,773,548.40
354	Хангамжийн материал	607,963,548.40	608,773,548.40
35410	Бичиг хэргийн материал	00.00	810,000.00
35420	Аж ахуйн материал	885,000.00	885,000.00
35470	Бусад хангамжийн материал	607,078,548.40	607,078,548.40
35500	Биологийн хөрөнгө	00.00	20,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,256,546,652.06</u>	<u>1,668,657,212.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,256,546,652.06	1,668,657,212.73
392	Биет хөрөнгө	1,214,686,652.06	1,628,071,212.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	531,927,688.89	955,969,072.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-64,146,907.76	-77,718,757.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	265,619,750.00	190,039,750.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-236,498,440.84	-134,774,173.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	196,433,750.00	217,430,010.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-88,362,923.54	-129,514,830.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,889,511.00	69,889,511.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-58,988,900.33	-64,232,385.59
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	184,777,590.00	00.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	652,609,462.00	884,656,035.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-238,573,927.36	-283,673,018.32
393	Биет бус хөрөнгө	41,860,000.00	40,586,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	41,860,000.00	40,586,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,865,824,799.46</u>	<u>2,405,475,149.13</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>21,823,725.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,823,725.00	00.00
413	Өглөг	21,823,725.00	00.00
4136	Бусад өглөг	21,823,725.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	21,823,725.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,844,001,074.46</u>	<u>2,405,475,149.13</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,844,001,074.46	2,405,475,149.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	689,815,330.77	689,815,330.77
51101	Өмч: - төрийн	689,815,330.77	689,815,330.77
512	Хуримтлагдсан үр дүн	805,801,407.33	1,367,275,482.00
51210	Өмнөх үеийн үр дүн	805,801,407.33	805,801,407.33
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	561,474,074.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	348,384,336.36	348,384,336.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,865,824,799.46</u>	<u>2,405,475,149.13</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	523,663,036.60	1,487,140,472.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,181,725.00	887,600,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,181,725.00	887,600,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,181,725.00	820,865,750.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,381,725.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,800,000.00	820,865,750.00
120009	Бусад орлого	00.00	66,735,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,481,311.60	599,539,722.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,718,140.00	94,440,322.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,196,000.00	27,439,950.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,087,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,401,164.00	1,655,273.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,033,376.00	65,345,099.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	423,763,171.60	505,099,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	423,763,171.60	505,099,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	503,811,220.55	667,124,952.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	503,811,220.55	667,124,952.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	482,622,913.10	613,760,634.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,751,280.15	270,757,875.12
210101	Үндсэн цалин	187,227,257.15	220,385,939.87
210102	Нэмэгдэл	00.00	11,412,479.80
210104	Урамшуулал	54,453,323.00	17,391,310.27
210105	Гэрээт ажлын хөлс	29,070,700.00	21,568,145.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,752,600.00	39,453,445.26
210201	Тэтгэврийн даатгал	22,958,400.00	27,789,948.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,698,500.00	2,622,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,159,000.00	3,048,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	539,200.00	559,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,397,500.00	5,433,196.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,657,888.00	54,287,384.00
210301	Гэрэл, цахилгаан	6,926,454.00	7,641,367.00
210302	Түлш, халаалт	58,921,434.00	45,836,017.00
210303	Цэвэр, бохир ус	810,000.00	810,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,827,506.00	29,383,516.00
210401	Бичиг хэрэг	5,102,500.00	4,894,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,895,566.00	22,647,816.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,734,040.00	1,680,000.00
210404	Ном, хэвлэл	95,400.00	160,800.00
2105	Нормативт зардал	151,700.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	151,700.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	2,677,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	2,677,500.00

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	1,672,000.00	2,138,000.00
210702	Дотоод албан томилолт	1,672,000.00	2,138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,609,720.00	48,426,488.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,232,100.00	47,453,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	307,200.00	273,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,500.00	273,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	47,920.00	36,008.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	226,000.00	302,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,700,218.95	166,636,425.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,821,431.00	35,627,681.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	795,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,878,787.95	130,213,744.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,188,307.45	53,364,318.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,853,900.00	25,340,086.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	90,720.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,193,400.00	8,102,680.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	12,511,936.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,560,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,100,000.00	4,634,750.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,334,407.45	28,024,232.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,334,407.45	28,024,232.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	19,851,816.05	820,015,519.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	258,541,445.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	258,541,445.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-258,541,445.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	19,851,816.05	561,474,074.67

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	689,815,330.77	348,384,336.36	805,801,407.33	1,844,001,074.46
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	689,815,330.77	348,384,336.36	805,801,407.33	1,844,001,074.46
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	561,474,074.67	561,474,074.67
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	689,815,330.77	348,384,336.36	1,367,275,482.00	2,405,475,149.13

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	465,863,036.60	600,439,722.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,381,725.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,381,725.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,381,725.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,381,725.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,481,311.60	600,439,722.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,718,140.00	95,340,322.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,196,000.00	27,439,950.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,087,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,401,164.00	1,655,273.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,033,376.00	66,245,099.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	423,763,171.60	505,099,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	423,763,171.60	505,099,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	465,863,036.60	600,439,722.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	465,863,036.60	600,439,722.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	443,774,729.15	507,760,403.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,751,280.15	271,172,474.12
210101	Үндсэн цалин	187,227,257.15	221,203,135.36
210102	Нэмэгдэл	00.00	11,412,479.80
210104	Урамшуулал	54,453,323.00	17,391,310.27
210105	Гэрээт ажлын хөлс	29,070,700.00	21,165,548.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,752,600.00	38,624,247.26
210201	Тэтгэврийн даатгал	22,958,400.00	26,960,750.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,698,500.00	2,622,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,159,000.00	3,048,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	539,200.00	559,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,397,500.00	5,433,196.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,542,821.00	77,251,168.00
210301	Гэрэл, цахилгаан	6,926,454.00	7,641,367.00
210302	Түлш, халаалт	38,806,367.00	68,799,801.00
210303	Цэвэр, бохир ус	810,000.00	810,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,827,506.00	30,193,516.00
210401	Бичиг хэрэг	5,102,500.00	5,704,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,895,566.00	22,647,816.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,734,040.00	1,680,000.00
210404	Ном, хэвлэл	95,400.00	160,800.00
2105	Нормативт зардал	151,700.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	151,700.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	2,677,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	2,677,500.00

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	1,672,000.00	2,138,000.00
210702	Дотоод албан томилолт	1,672,000.00	2,138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,609,720.00	48,426,488.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,232,100.00	47,453,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	307,200.00	273,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,500.00	273,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	47,920.00	36,008.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	226,000.00	302,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,967,102.00	37,277,010.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,967,102.00	36,482,010.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	795,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,088,307.45	92,679,318.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,753,900.00	25,340,086.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	90,720.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,193,400.00	8,102,680.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	12,511,936.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,560,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	4,634,750.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,334,407.45	67,339,232.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,334,407.45	22,477,059.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	506,094,100.00	482,622,340.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	506,094,100.00	482,622,340.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	480,787,800.00	458,182,254.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,797,600.00	268,640,376.12
210101	Үндсэн цалин	235,380,100.00	218,671,037.36
210102	Нэмэгдэл	12,553,100.00	11,412,479.80
210104	Урамшуулал	00.00	17,391,310.27
210105	Гэрээт ажлын хөлс	30,864,400.00	21,165,548.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,017,000.00	38,464,015.26
210201	Тэтгэврийн даатгал	28,867,200.00	26,800,518.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,909,100.00	2,622,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,208,800.00	3,048,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	307,700.00	559,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,724,200.00	5,433,196.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,536,400.00	73,536,400.00
210301	Гэрэл, цахилгаан	5,076,000.00	5,607,842.00

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	67,650,400.00	67,118,558.00
210303	Цэвэр, бохир ус	810,000.00	810,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,195,900.00	13,240,040.00
210401	Бичиг хэрэг	4,441,900.00	3,551,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,943,200.00	7,877,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,650,000.00	1,650,000.00
210404	Ном, хэвлэл	160,800.00	160,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,138,000.00	2,138,000.00
210702	Дотоод албан томилолт	2,138,000.00	2,138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,302,900.00	48,426,488.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,000,000.00	47,453,230.00
210803	Даатгалын үйлчилгээ	373,900.00	273,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	276,000.00	273,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	80,000.00	36,008.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	386,000.00	302,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14800000.00	12736935.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,000,000.00	11,941,935.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	795,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25306300.00	24440086.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,306,300.00	24,440,086.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	90,720.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,193,400.00	8,102,680.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,512,900.00	12,511,936.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,600,000.00	3,734,750.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	506,094,100.00	482,622,340.38
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	506,094,100.00	482,622,340.38
132001	Орон нутгийн төсвөөс	506,094,100.00	482,622,340.38
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,478,149.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,478,149.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,578,149.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,532,098.00
210101	Үндсэн цалин	2,532,098.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,232.00
210201	Тэтгэврийн даатгал	160,232.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,714,768.00
210301	Гэрэл, цахилгаан	2,033,525.00
210302	Түлш, халаалт	1,681,243.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,953,476.00

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,153,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,770,476.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,677,500.00
210604	Урсгал засвар	1,677,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,540,075.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,540,075.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,478,149.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,478,149.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	27,439,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,655,273.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,382,926.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Алтансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газар нь “Иргэдээ хөгжүүлэн иргэн, өрх бүр ашиг орлоготой байж, амьдарч.ажиллаж байгаа орчиндоо сэтгэл хангалуун байх таатай нөхцөл

боломжийг бүрдүүлж, хамтын оюун, хичээл зүтгэлтэй сум болох.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 503.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 539,650.3 мянган төгрөгөөр буюу 28.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, авлага болон материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,314.6	108,044.4	106,729.8
Бараа материал	607,963.5	628,773.5	20,810.0
Үндсэн хөрөнгө	1,256,546.7	1,668,657.2	412,110.6
Нийт хөрөнгө	1,865,824.8	2,405,475.1	539,650.3
Богино хугацаат өр төлбөр	21,823.7	-	- 21,823.7
Нийт өр төлбөр	21,823.7	-	- 21,823.7
Засгийн газрын оруулсан капитал	689,815.3	689,815.3	-
Хуримтлагдсан үр дүн	805,801.4	1,367,275.5	561,474.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	348,384.3	348,384.3	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,865,824.8	2,405,475.1	539,650.3

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,668.657.2 мянган төгрөг болж 412,110.6 мянган төгрөгөөр, бараа материалын дансны үлдэгдэл 628,773.5 мянган төгрөг болж, 20,810.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өсөхөд тайлант онд 800,865.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан нь нөлөөлжээ.

Авлагын дансны үлдэгдлийн хувьд Сүхбаатар сумын ЗДТГ-аас 2017 оноос хэрэгжүүлж байгаа "Малжуулах хөтөлбөр"-ийн 950 эм хонийг 9 иргэнд 106,050.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсантай холбоотой 66,735.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл, тайлант оны эцэст борлуулалтаас орж ирсэн мөнгөн хөрөнгө орон нутгийн төсөвт татагдсантай холбоотой авлага 39,315.0 мянган төгрөг, түлш халаалтын зардлын авлага 1,994.4 мянган төгрөгийн авлага нөлөөлжээ. Бараа материалын дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн хүчин зүйлийг авч үзэхэд малын чанарыг сайжруулах зорилгоор Үзэмчин, Баяндэлгэрийн улаан үүлдрийн өсвөр хээлтүүлэгч бойжуулж, бог малын цөм сүрэг бий болгох ажилд ОНХС-аас 20,000.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулж, 70 хурган хуц, 30 ишгэн ухныг данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 963,477.4 мянган төгрөгөөр буюу 184.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 763,065.8 мянган төгрөгөөр өсөж, тайлант үед 820,865.8 мянган төгрөг болсон байна.

Нийт зардал өмнөх оноос 421,855.2 мянган төгрөгөөр өсөж, тайлант онд 925,666.4 мянган төгрөг болсон байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол болон үндсэн хөрөнгө худалдсаны гарз гэсэн зардлууд байна. Тодруулбал өмнөх оноос үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол 112,335.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө худалдсаны гарз 258,541.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 430,897.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 430,897.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 48,201.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 479,099.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор төсөв 27,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 506,099.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тухайн байгууллагын 2021 онд 10 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 81 арга хэмжээ бүхий “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” 85.3 хувьтай хэрэгжсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 506,099.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 506,099.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 505,099.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 482,622.3 мянган төгрөгийг зарцуулж, 22,477.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 482,622.3 мянган төгрөг буюу 95.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 12,710.2 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардал 4,065.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ковид цар тахалтай холбоотойгоор иргэдээс 27,439.9 мянган төгрөгийн хандив, дээд шатны төсөв захирагчаас 1,655.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 66,245.1 мянган төгрөг, нийт 95,340.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 50,478.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 44,862.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргын ажлын алба бөгөөд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д заасан 8 чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 6 арга хэмжээний хэрэгжилт 85.3 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж, зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.4 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд санхүүжилтийг мэдээлээгүй, жилийн дүн нь 5 сая төгрөгөөс дээш бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-З/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан бөгөөд зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 1,994.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 86,735.0 мянган төгрөгийн алдааг залруулж, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, шилэн данстай холбоотой 3 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

1. Малын чанарыг сайжруулах зорилгоор Үзэмчин, Баяндэлгэрийн улаан үүлдрийн өсвөр хээлтүүлэгч бойжуулж, бог малын цөм сүрэг бий болгох ажил үйлчилгээний гэрээний дагуу ОНХС-аас 20,000.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Үзэмчин үүлдрийн 70 хурган хуц, Баяндэлгэрийн улаан үүлдрийн 30 ишгэн ухныг сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 дахь заалттай нийцэхгүй байна. Иймд санхүүгийн тайланд залруулга хийлгэж, эргэлтийн хөрөнгөд бүртгүүлсэн.

2. Сүхбаатар сумын ЗДТГ-аас 2017 оноос хэрэгжүүлж байгаа "Малжуулах хөтөлбөр"-ийн 950 эм хонийг 9 иргэнд 106,050.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд 66,735.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 дахь заалттай нийцэхгүй байна. Иймд санхүүгийн тайланд залруулга хийлгэж, авлагаар тусгуулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Тайлант оны эцэст 1,994.4 мянган төгрөгийн түлш халаалтын авлагын үлдэгдэлтэй буюу төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 7.7, 45.2 дахь заалтыг зөрчсөн. Иймд төлбөрийн акт тогтоосон.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 208 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Богино хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд татварын өглөг, авлага тусгагдаагүй байхад татварын байгууллагын тодорхойлолтоор 9 нэр төрлийн татвар 57,565.8 мянган төгрөгийн илүү, 6 нэр төрлийн татвар 9,421.6 мянган төгрөгийн дутуу төлөлттэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагын тодорхойлолт дахь татварын илүү, дутуу төлөлтийг татварын байгууллагатай тооцоо нийлж, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд санхүүжилтийг мэдээлээгүй, жилийн дүн нь 5 сая төгрөгөөс дээш бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газар	5	88.7	2	86.7	1	2.0	0	0	2	0
Дүн		5	88.7	2	86.7	1	2.0	0	0	2	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газар	1	0	0	0	0	0	0	0	1	0
Дүн		1	0	0	0	0	0	0	0	1	0
Нийт дүн		6	88.7	2	86.7	1	2.0	0	0	3	0